



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/09

Хэрлэн сум

Газар эзэмших гэрчилгээг нэгтгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.4-д заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын 3 дугаар багийн иргэн Уртнасангийн Зоригоо (УС68012331)-ийн ирүүлсэн хүсэлтийн дагуу тус иргэний эзэмшлийн Хэрлэн сумын 3 дугаар баг (Өндөрхаан) Тэмүүжингийн гудамж байрлах 2220м<sup>2</sup> бүхий үйлчилгээний зориулалттай газрыг 45 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Иргэн У.Зоригоогийн эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү)-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн У.Зоригоод даалгасугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2004 оны А/58 дугаар захирамжийн дугаар хавсралт, 2011 оны А/377 дугаар захирамжуудийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010027